

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны
09 дүгээр сарын 15-ны өдрийн Ээлжит бус III
хуралдааны 09 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

“ЭХ ХЭЛ-ЭРДЭНЭТ” ХӨТӨЛБӨР

НЭГ. ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ

“Эх хэл-Эрдэнэт” хөтөлбөрийг Монгол хэлний тухай хууль, Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол улсын Ерөнхийлөгчийн “Эх хэлний өдөр зарлах тухай” 2017 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн зарлиг, Монгол улсын Ерөнхийлөгчийн “Монгол хэл, бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018 оны 05 дугаар сарын 03 ны өдрийн 46-р зарлиг, 2013 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн “Монгол хэл, бичгийн боловсролыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоол, Монгол улсын Засгийн газрын 96-р тогтоолоор батлагдсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”, Монгол улсын урт хугацааны хөгжлийн “Алсын хараа-2050” бодлогын баримт бичиг, “Хэлний бодлогын Үндэсний зөвлөл”-ийн 2018 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 06 тоот зөвлөмж зэрэг бодлогын баримт бичгүүдэд нийцүүлэн Засгийн газрын 2021 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын дагуу боловсруулсан.

Орхон аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 1.2.1-д “Монгол хэл, бичгийн боловсролыг сурагчдад эзэмшүүлэх, арга технологи, орчин бүрдүүлэлтийг сайжруулан сургалтын чанарыг дээшлүүлнэ”, 1.2.2-т “Монгол хэл, бичгийг нийтийн болон албан хэргийн түвшинд зөв хэрэглэж хэвшүүлэх “Эх хэл-Эрдэнэт” төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан нь уг хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх гол үндэслэл болно.

ХОЁР.ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол улс 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон Монгол бичгээр хөтлөн явуулах болсонтой холбогдуулан бүх нийтээр Монгол бичигт шилжих бэлэн байдлыг судлах зорилгоор Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Үндэсний статистикийн газраас 2021 онд “Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа”-г авсан байна. Уг судалгаанд Орхон аймгийн 4294 төрийн албан хаагч хамрагдсан бөгөөд судалгаанд хамрагдсан нийт төрийн албан хаагчдын 77,0 хувь нь үндэсний бичгийн тодорхой түвшний мэдлэгтэй, үүнээс 19,9 хувь нь сайн мэддэг гэж хариулсан бол, 23,0 хувь нь огт мэддэггүй гэж хариулсан байна.

Өнгөрсөн жилүүдэд “Монгол хэлний тухай хууль”-ийн 6.1.7 дахь заалт, Монгол улсын Ерөнхийлөгчийн “Монгол хэл, бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай” 2018 оны 46-р зарлиг, Засгийн газрын 2013 оны 37-р тогтоолын 5 дахь заалтад тусгагдсан “Албан байгууллага, аж ахуйн нэгжийн хаягийг кирилл, монгол хос бичгийн хаягтай болгох” зорилтыг Орхон аймагт хэрэгжүүлж төрийн байгууллагуудын 90 орчим хувь, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн 15 орчим хувь нь хос бичгийн хаягтай болсон ч аймгийн албан байгууллагуудын хаягжилтын стандартыг тогтоож, журамласан нэгдсэн бодлого, шийдвэр өнөөг хүртэл гараагүй байна.

Өнөөдрийн байдлаар Орхон аймагт Монгол хэл, бичгийн 105 багш ажиллаж байна. Боловсролын үнэлгээний төвөөс авдаг чанарын үнэлгээний дүнгээр Монгол хэл, бичгийн хичээлээр бага анги 44,6 хувийн үнэлгээтэй байгаа нь улсын дунджаас 7,2 хувиар илүү, дунд анги 51,2 хувь байгаа нь улсын дунджаас 0,7 хувиар илүү, ахлах ангид 40,3 байгаа нь улсын дунджаас 9,3 хувиар бага байна.

Мөн ЭЕШ-ын монгол хэл, бичгийн хичээлийн сүүлийн 5 жилийн дундаж үзүүлэлт улсын дунджаас 7,1 хувиар илүү, гүйцэтгэлийн хувь жил ирэх тусам өсөж байгаа хэдий ч улсад 15-18-р байранд эрэмбэлэгдэж байна.

Эдгээрээс үзвэл төрийн албан хаагчдын монгол хэл, бичгийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн монгол хэл, бичгийн хичээлийн сургалтын чанарыг сайжруулах, нийгэм, ахуйн хүрээнд үндэсний бичгийн орчин бүрдүүлж, хэрэглээг нэмэгдүүлэх, үндэсний хэл, соёлоо түгээн дэлгэрүүлэх асуудлыг бодлогын хэмжээнд авч үзэх шаардлага зүй ёсоор урган гарч байна.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Эрдэнэт хотын иргэд, хүүхэд багачуудын эх хэлний боловсролыг дээшлүүлж, Монгол бичгийн сургалт, сурталчилгаа, хэрэглээний орчин бүрдүүлэх, албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулах бэлтгэлийг хангахад хөтөлбөрийн зорилго оршино.

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ

- Зорилт 1. Монгол бичгийн сургалт сурталчилгаа хэрэглээний орчин бүрдүүлэх
- Зорилт 2. Бүх нийтийг монгол бичигт сургах ажлыг эрчимжүүлж, албан хэргийг кирилл, монгол хос бичгээр хөтлөн явуулах бэлтгэлийг хангах
- Зорилт 3. Эх хэлний сургалтын чанарыг дээшлүүлэх, багшлах боловсон хүчнийг чадваржуулах
- Зорилт 4. Монгол хэл, утга зохиолын нөхцөл байдалд үнэлгээ хийж, үнэлэмжийг дээшлүүлэх, хэл аялгуу, бичгийн өв соёлыг судлан хамгаалж өвлүүлэх

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗАРЧИМ

5.1.Хөтөлбөр нь "Монгол хэлний тухай хууль", "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр –III"-ын хэрэгжилтийг хангахад чиглэгдэж, байгууллага аж ахуй нэгж, иргэдийн идэвхтэй оролцоонд тулгуурлах

5.2.Хөтөлбөрийг улс орон, аймаг, орон нутгийн эдийн засгийн таатай нөхцөл байдал болон хямралтай, хүнд, аль ч үед санхүүгийн найдвартай эх үүсвэрээр хангах

5.3.Хөтөлбөрийг түүх, соёл, боловсрол, сургалтын бодлого, үйл ажиллагаатай уялдуулах

5.4.Хөтөлбөрт цаг үе, нийгмийн шаардлагад нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой байх

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

6.1.Монгол бичгийн сургалт сурталчилгаа, хэрэглээний орчин бүрдүүлэх зорилтын хүрээнд:

6.1.1.Аймгийн хэмжээнд мөрдөх хаягжилтын нэгдсэн журам, стандарттай болж, журмын дагуу аймгийн бүх албан байгууллагуудыг кирилл болон үндэсний бичгийн хаягтай болгох

6.1.2.Орон нутгийн төрийн болон хувийн хэвшлийн аж ахуй нэгж байгууллагуудын бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа, нэрийн хуудас, шагнал урамшуулал, албан байгууллагын орчны тохижилтыг үндэсний бичигтэй болгож, үндэсний бичгийн хэрэглээний орчин бүрдүүлэхийг уриалах, дэмжиж урамшуулах, сурталчлах

6.1.3.Орон нутгийн телевиз, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран монгол хэл, бичиг, уран зохиол, ном унших арга зүйг дэмжсэн TV хичээл, уралдаан, цэнгээнт нэвтрүүлэг бэлтгэн олны хүртээл болгох, энэ чиглэлээр мэдээ мэдээлэл, контент бэлтгэж идэвхтэй ажилласан телевиз, хэвлэл мэдээллийн байгууллагуудад дэмжлэг үзүүлэх

6.1.4.Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын нэвтрүүлэг, мэдээ нийтлэлийн 30-аас доошгүй хувийг монгол бичгээр хөтлөн явуулдаг болгох

6.1.5.Монгол бичгээр уламжлан ирсэн түүх соёлын үнэт дурсгалуудыг хамгаалах, түүх, уран зохиолын болон монгол хэл, бичгийн ном сурах бичиг, гарын авлагыг хэвлэн нийтэлж олны хүртээл болгох

6.1.6.Цахим орчинд монгол бичгээр бичвэр оруулах, түүнийг унших, хэрэглэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах ажлыг дэмжих

6.2.Бүх нийтийг монгол бичигт сургах ажлыг эрчимжүүлж, албан хэргийг кирилл, монгол хос бичгээр хөтлөн явуулах бэлтгэлийг хангах зорилтын хүрээнд :

6.2.1.Төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын ажилтан, албан хаагчдын монгол бичгээр унших, бичих чадварын суурь судалгаатай болох, судалгаанд тулгуурлан анхан, дунд, гүнзгийрүүлсэн шатны сургалтыг үе шаттай, олон арга хэлбэрээр зохион байгуулах

6.2.2.Аймгийн төрийн байгууллагуудын удирдах ажилтны үр дүнгийн гэрээ, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд ажилтнуудаа монгол бичигт сургах ажлыг заавал тусгаж, үр дүнг тайлагнах, байгууллага бүр монгол хэл, бичгийн сургагч багштай болж тэдгээрээр дамжуулан монгол бичгийн сургалтыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

6.2.3.Монгол бичиг сурч, судалж, зааж сургаж байгаа иргэд, байгууллагуудын дунд төрөл бүрийн уралдаан тэмцээн зохион байгуулах, аян өрнүүлэх, идэвхтэй ажиллаж байгаа байгууллага, иргэд, гэр бүл, багш, сурагчдыг дэмжих, урамшуулах

6.2.4.Монгол хэл, бичгийн чиглэлээр сургалт сурталчилгаа явуулж буй хувь хүн, хуулийн этгээдийг дэмжих, хамтран ажиллах

6.2.5.Монгол бичгийн анхан, дунд, гүнзгийрүүлсэн шатны мэдлэг чадварын түвшин тогтоох шалгалтын тест, даалгаврын сан бүрдүүлэх, төрийн албан хаагчдад үндэсний бичгийн мэдлэг, чадварыг тодорхойлсон сертификат олгодог болох

6.2.6.Төрийн бүх шатны байгууллагуудад төрийн албан хэргийг батлагдсан стандартын дагуу хос бичгээр үйлдэж хэвшихэд дэмжлэг үзүүлэх

6.3. Эх хэлний сургалтын чанарыг дээшлүүлж, багшлах боловсон хүчнийг чадваржуулах зорилтын хүрээнд:

6.3.1.Мэргэжлийн багш нарын арга зүйг хөгжүүлэн, шинэ санаа, арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах, дэмжих

6.3.2.Монгол хэл, бичгийн хичээлээр 6-12-р ангид анги нийтийн уралдааныг тогтмол зохион байгуулдаг болох

6.3.3.Монгол хэл, бичиг, уран зохиолын хичээлийн сургалтын хэрэглэгдэхүүн, ном, сурах бичиг, гарын авлагыг хэвлүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, кабинет байгуулахад дэмжлэг үзүүлэх

6.3.4.ЭЕШ, монгол хэлний бүх нийтийн шалгалт, монгол хэл, бичгийн улсын олимпиад, аймаг, бүсийн уралдаан тэмцээнд амжилттай оролцож, амжилт гаргасан багш сурагчдыг урамшуулах

6.4. Монгол хэл, утга зохиолын нөхцөл байдалд үнэлгээ хийж, үнэлэмжийг дээшлүүлэх, хэл аялгуу, бичгийн өв соёлыг судлан хамгаалж өвлүүлэх зорилтын хүрээнд:

6.4.1.Эрдэнэт хотод ажиллаж амьдарч буй гадаадын иргэд болон гадаад улс оронд олон жил ажиллаж амьдарч байсан монгол иргэд, үндэстний цөөнхийн, хэл, сонсголын бэрхшээлтэй хүүхэд багачууд, иргэдийн судалгааг гаргаж тэдэнд зориулсан сургалтын хөтөлбөр, ном сурах бичиг, хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, сургалт зохион байгуулах

6.4.2.Хэл шинжлэлийн эрдэмтэн, судлаач, багш нартай хамтран ажиллаж, судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх, сургуулийн өмнөх боловсрол болон сургуулийн насны хүүхдийн хэл ярианы хөгжилд судалгаа хийх, шинэ арга зүй боловсруулах, судалгааны ажлын үр дүнг аймаг, улсын хэмжээнд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх

6.4.3.“Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг аймгийн Номын төвтэй хамтран тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулах

ДОЛОО. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА, ҮЕ ШАТ

7.1. Хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлнэ.

НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН, АЧ ХОЛБОГДОЛ

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.

8.1.Төрийн байгууллагын ажилтан, албан хаагчдын 90 хувь, хувийн хэвшлийн аж ахуй нэгжийн ажилтнуудын 40 хувийг үндэсний бичгийн анхан, дунд, гүнзгий шатны мэдлэгтэй болгож, төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулах бэлтгэлийг хангана.

8.2.Аймгийн байгууллага, аж ахуйн нэгжүүд хаягийн нэгдсэн стандарттай болж, төрийн байгууллагууд 100 хувь, хувийн хэвшлийн байгууллагын 50 хувь нь хос бичгийн хаягтай болно.

8.3.Бага анги, монгол хэл бичгийн багш нарын онолын мэдлэг дээшилж, монгол хэлний сургалтын чанарт ахиц гарна.

8.4.Иргэд, олон нийтийн эх хэлээ дээдлэх, түүнийг сурч судлах, зөв хэрэглэх, өвлүүлэх, хамгаалах, хөгжүүлэх үйл хэрэгт оролцох оролцоо нэмэгдэнэ.

8.5.Үндэсний бичгээр хэвлэгддэг ном сурах бичиг, нэвтрүүлэг, контентын тоо нэмэгдэж, нийгэм, ахуйн хүрээнд үндэсний бичгийн хэрэглээний орчин бүрдэнэ.

8.6.Аймгийн нийт хэлний болон сонсголын бэрхшээлтэй иргэд, гадаад иргэд, эх хэлний тусгай хөтөлбөрөөр хичээллэдэг иргэд, хүүхэд багачуудад зориулсан сургалтын хөтөлбөр, сургалтын хэрэглэгдэхүүн, ном сурах бичгийн хүрэлцээ хангамж сайжирч, сурч хөгжих таатай нөхцөл бүрдэнэ.

ЕС. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

9.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг Боловсрол, соёл, урлагийн газар болон аймгийн Хэлний бодлогын салбар зөвлөл хариуцна.

9.2.Төрийн захиргаа, нутгийн удирдлагын байгууллага, бусад байгууллагууд хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

9.3.Хэлний бодлогын салбар зөвлөл нь хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр аймгийн Засаг даргын захирамжаар батлуулна.

АРАВ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

10.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээр санхүүжүүлнэ.

10.1.1.Улсын болон орон нутгийн төсөв

10.1.2.Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж

10.1.3.Гадаадын болон дотоодын төсөл хөтөлбөр

10.1.4.Олон улсын байгууллагын хандив, тусламж зэрэг санхүүжилтийн эх үүсвэртэй байна.

10.1.5.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгаас шаардагдах хөрөнгийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж санхүүжүүлнэ.

АРВАН НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

11.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ бүрээр жилд 2 удаа гаргаж, Хэлний бодлогын салбар зөвлөлийн хурал, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, жил бүрийн 4-р улиралд багтаан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.

12.2.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний болон хөндлөнгийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

АРВАН ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь				Зорилгот түвшин				Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
			түвшин	он	2021 он	2022 он	2023 он	2024 он					
<p>Зорилго. Эрдэнэт хотын нийт иргэд, хүүхэд багачуудын эх хэлний боловсролыг дээшлүүлж, монгол бичгийн сургалт, сурталчилгаа, хэрэглээний орчин бүрдүүлэх, албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулах бэлтгэлийг хангах</p> <p align="center">Зорилт 1. Монгол бичгийн сургалт сурталчилгаа хэрэглээний орчин бүрдүүлэх</p>													
1	Хос бичгийн хаягтай байгууллага аж ахуйн нэгжийн тоо	Хувь	90 хувь, хувийн хэвшлийн байгууллагын 15 хувь хос бичгийн хаягтай	2020	лага 90 хувь, хувийн хэвшлийн байгууллагын 20 хувь	Төрийн байгууллага лага 95 хувь хувийн хэвшлийн байгууллагын 30 хувь	Төрийн байгууллага 100 хувь хувийн хэвшлийн байгууллагын 40 хувь	Төрийн байгууллага 100 хувь хувийн хэвшлийн байгууллагын 50 хувь	Төрийн байгууллага 100 хувь хувийн хэвшлийн байгууллагын 50 хувь	ХБСЗ-өөс авсан судалгааны дүнгээр тооцно.	Хагас жил тутамд	ХБСЗ Хотын захирагчийн алба	
2	TV нэвтрүүлэг контентын тоо	Тоо	3	2020	3	4	5	6	Иргэд олон нийтэд хүрсэн контентын тоогоор	Хагас жил тутамд	Орон нутгийн телевиз		
<p align="center">Зорилт 2. Бүх нийтийг монгол бичигт сургах ажлыг эрчимжүүлж, албан хэргийг кирилл, монгол хос бичгээр хөтлөн явуулах бэлтгэлийг хангах</p>													
3	Үндэсний бичгийн дундаас дээш түвшний мэдлэгтэй төрийн албан хаагчийн тоо	Хувь	20	2020	30-40	40-50	50-60	70-80	ХБСЗ-өөс авсан шалгалтын дүнгээр	Хагас жил тутамд	ХБСЗ		
4	Үндэсний бичгийн шалгалтын төстийн сан	Тоо	Төстийн тоо 20-300	2020	300-500	500-700	700-900	900-1000	ХБСЗ-өөс боловсруулсан төстийн сангаар	Жилд 1 удаа	ХБСЗ		
<p align="center">Зорилт 3. Эх хэлний сургалтын чанарыг дээшлүүлэх, багшлах боловсон хүчнийг чадваржуулах</p>													
5	Арга туршлагаа түгээн дэлгэрүүлсэн багшийн тоо, хувь	Хувь	5	2020	6	15	20	25	Улс аймгийн хэмжээнд арга туршлагаа түгээн дэлгэрүүлсэн багшийн тоогоор	Жилд 1 удаа	ХБСЗ БСУГ		
6	Масс сургалтын чанар, үр дүн	Хувь	45,3	2020	48,5	50,5	52,5	55	БҮТ-ийн чанарын үнэлгээний шалгалтын дүнгээр	Жилд 1 удаа	БСУГ		
7	ЭЭШ-ын дүн	Хувь	510	2020	515	520	525	528	ЭЭШ-ын дүнгээр	Жилд 1 удаа	БСУГ		
<p align="center">Зорилт 4. Монгол хэл, утга зохиолын нөхцөл байдалд үнэлгээ хийж, үнэлэмжийг дээшлүүлэх хэл аялгуу, бичгийн өв соёлыг судлан хамгаалж өвлүүлэх</p>													
8	Хэлний чиглэлээр хийсэн судалгаа шинжилгээний бүтээлийн тоо	Тоо	0	2020	0	1-2	3	4-5	Судалгаа шинжилгээний бүтээлийн тоогоор	Жилд 1 удаа	ХБСЗ		

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн Ээлжит бус III хуралдааны шүүдугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

“ЭХ ХЭЛ-ЭРДЭНЭТ” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ, 2021-2024 (78.4 сая.төг)	Зорилтот түвшин, үр дүн, төсөв (сая.төг)				Хэрэгжүүлэх байгууллага					
						2021он		2022 он		2023 он		2024 он		Үндсэн	Хамтрагч
						Үр дүнгийн үзүүлэлт	Төсөв, сая.төг	Үр дүнгийн үзүүлэлт	Төсөв, сая.төг	Үр дүнгийн үзүүлэлт	Төсөв, сая.төг	Үр дүнгийн үзүүлэлт	Төсөв, сая.төг		
Зорилго: Эрдэнэт хотын нийт иргэд, хүүхэд багачуудын эх хэлний боловсролыг дээшлүүлж, Монгол бичгийн сургалт, сурталчилгаа, хэрэглээний орчин бүрдүүлэх, албан хэргийг хөтлөн явуулах бэлтгэлийг хангах															
Зорилт 1: Монгол бичгийн сургалт сурталчилгаа хэрэглээний орчин бүрдүүлэх															
1.1 Аймгийн хэмжээнд мөрдөх хягажилтын нэгдсэн журам, стандарттай болж, журмын дагуу хотын бүх албан байгууллагуудыг кирилл болон үндэсний бичгийн хаягтай болгох	1	1.1.1 Эрдэнэт хотын хэмжээнд мөрдөх хягажилтын нэгдсэн журам, стандарттай болж, журмын дагуу хотын бүх албан байгууллагуудыг кирилл болон үндэсний бичгийн хаягтай болгох	2022	-	-	Стандартыг боловсруулж батлуулах	-	-	-	-	БСУГ ХБСЗ	ХЗА			
	2	1.1.2 Аймгийн нийт албан байгууллагуудыг хийсэн гадна дотно хаягтай болгох аян хөдөлгөөн өрнүүлэх, сурталчлах, дэмжих	2022-2024	ОНТ	1.5	Төрийн байгууллагыг 100% хувийн хэвшлийн байгууллагын 30%	0.5	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг 40%	0.5	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг 50%	БСУГ ХБСЗ	ХЗА			
	3	1.1.3 Байгууллагуудын хос бич, йн хягажилтын нэгдсэн судалгаа бүртгэлтэй болох үр дүнг тасрах	2022-2024	-	-	Төрийн байгууллагыг 100% хувийн хэвшлийн байгууллагын бүртгэл 25 %	-	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн 50%	-	-	БСУГ ХБСЗ	ХЗА			
1.2 Орон нутгийн төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудын бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа, нэрийн хуудас, шанал урамшуулал, албан байгууллагын орчны тохижилтыг үндэсний бичгтэй болгож, үндэсний бичгийн хэрэглээний орчин бүрдүүлэхийг уриалах, дэмжих	4	1.2.1 Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн үйлдвэрүүдэд сургалт зохион байгуулж хэлний тухай хууль тогтоомжуудыг сурталчлах	2021-2024	ОНТ	1.5	Цахим болон танхимын уулзалт 1 удаа хийсэн байна	0.5	Цахим болон танхимын уулзалт 1 удаа хийсэн байна	0.5	Цахим болон танхимын уулзалт 1 удаа хийсэн байна	БСУГ ХБСЗ	ХАУТ			
	5	1.2.2 Бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэдэг бүтээгдэхүүний нэрийг	2021-2024	ОНТ	0.2	Бүтээгдэхүүний жагсаалтыг аж ахуйн нэгжээс авч Монгол	0.2	Бүтээгдэхүүний нэрийн сангтай болно.	0.2	Санг баяжуулна	БСУГ ХБСЗ	ААН, байгууллагууд			

Урамшуулах, сурталчлах	Үндэсний бичгээр бичсэн сан бүрдүүлэх	2021-2024	ОНТ	2.2	-	Эх бэлтгэдэг иргэд аж ахуйн нэгжийн дунд хагяг шошгын загвар бүтээх уралдаан зарлана.	0.2	Бүтээгдэ хүүн үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжийн дунд уралдаан зохион байгуулна.	1.0	Орхон аймагт үйлдвэрлэдэг бүх бүтээгдэхүүний хагяг шошго үндэсний бичгээр болон кирилл бичгээр бичигддэг болсон байна.	1.0	БСУГ ХБСЗ	ХАУТ ШӨХТГ ААН
6	1.2.3 Бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүдийн дунд хагяг шошгоо хос бичгээр бичих үндэсний бичгийн харгалзаны орчин бүрдүүлэх яан, уралдаан зарлаж дүгнэх, идэвхтэй ажилласан байгууллагыг дэмжих урамшуулах	2021-2024	ОНТ	2.2	-	Эх бэлтгэдэг иргэд аж ахуйн нэгжийн дунд хагяг шошгын загвар бүтээх уралдаан зарлана.	0.2	Бүтээгдэ хүүн үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжийн дунд уралдаан зохион байгуулна.	1.0	Орхон аймагт үйлдвэрлэдэг бүх бүтээгдэхүүний хагяг шошго үндэсний бичгээр болон кирилл бичгээр бичигддэг болсон байна.	1.0	БСУГ ХБСЗ	ХАУТ ШӨХТГ ААН
7	1.3.1 Орон нутгийн телевизүүдтэй хамтран иргэдэд зориулсан "Зөв бичих дүрэм", найруулга зүй, үндэсний бичгийн анхан, дунд гүнзгийрүүлсэн шатны цахим орчинд үндэсний бичгээр бичвэр оруулах, үндэсний бичгээр эх бэлтгэх сургалт явуулах	2021-2024	ОНТ	4.5	-	"Зөв бичих дүрмийн хичээл" Цахим эх бэлтгэх хичээл	1.5	Үндэсний бичгийн хичээл	1.5	Үндэсний бичгийн хичээл	1.5	БСУГ ХБСЗ	Орон нутгийн TV-үүд
8	1.3.2 Орон нутгийн телевизүүдтэй хамтран байгууллага, иргэд хүүхэд багачуудад чиглэсэн эх хэлээ сурах хүсэл сонирхлыг дэмжсэн нэвтрүүлэг, контент бүтээх	2022-2024	ОНТ	4.5	3	1-2 нэвтрүүлэг	1.5	1-2 нэвтрүүлэг	1.5	1-2 нэвтрүүлэг	1.5	БСУГ ХБСЗ	Орон нутгийн TV-үүд
9	1.3.3 Аймгийн Хэлний бодлогын салбар зөвлөлөөс зохион байгуулж байгаа үйл ажиллагааг сурталчилсан TV нэвтрүүлэг бэлтгэж хүргэх	2021-2024	ОНТ	1.5	-	"Эх хэл - Эрдэнэт" дэд хөтөлбөрийн тайлан нэвтрүүлэг бэлдэнэ	0.5	ХБСЗ-өөс зохион байгуулж байгаа арга хэмжээ бүрээс мэдээлнэ.	0.5	"Эх хэл - Эрдэнэт" дэд хөтөлбөрийн тайлан нэвтрүүлэг бэлдэнэ	0.5	ХБСЗ	Орон нутгийн TV-үүд
10	1.4.1 Телевизийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, Хэлний тухай хууль дүрэм, төсөл хөтөлбөрийг танилцуулж, мэдээ мэдээллийн 30 хүртэлх хувийг монгол бичгээр бичдэг болгох талаар чиглэл өгөх	2021-2024	-	-	-	Мэдээ мэдээллийн 10%	-	Мэдээ мэдээллийн 20%	-	Мэдээ мэдээллийн 30%	-	ХБСЗ	Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл
11	1.5 Монгол бичгээр уламжлан ирсэн түүх соёлын үнэт	2022-2024	ОНТ	0.5	-	Иргэдийн гар дээр хадгалгагдаж	-	Иргэдийн гар дээр хадгалгагдаж	0.5	-	-	ХБСЗ	Номын төв

дүрсгалуудыг хамгаалах, түүх, уран зохиолын болон, монгол хэл, бичгийн ном сурах бичиг, гарын авлагыг хэвлэн нийтэлж олны хүртээл болгох		хүүчин ном, судар зэргээр үзэсгэлэн гаргах								ирсан түүх соёлын үнэт бүтээлийн үзэсгэлэн гаргах						Монгол хэлний мэргэжлийн эрдэмтэн, багш нар	
12		1.5.2 Монгол хэл, бичиг, уран зохиолын чиглэлээр багш нарын болон ирсэдийн бүтээж туурвисан ном зохиол, сурах бичиг гарын авлагыг хэвлүүлэх олны хүртээл болгох	2022-2024	ОНТ	6.0	2			2 ном, гарын авлага	2.0	2.0	2 ном, гарын авлага	2.0			ХБСЗ	
13		1.5.3 Хэлний зөвлөлөөс дамжин хэвлүүлсэн ном гарын авлагын үзэсгэлэн гаргах	2021-2024	ОНТ					Бүтээлийг олон нийтэд сурталчилна.			Бүтээлийг олон нийтэд сурталчилна.				ХБСЗ	Номын төв Соёлын хэлтэс
14	1.6 Цахим орчинд Монгол бичгээр бичвэр оруулах, түүнийг унших, хэрэглэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах ажлыг Дэмжих	1.6.1 Мэргэжлийн багш нарт цахим орчинд монгол бичгээр эх бэлтгэх бичвэр оруулах сургалтуудыг үе шаттай зохион байгуулах	2022	ОНТ	0.4		1 программ дээр ажиллаж сурна.	0.2	Багш бүр 2-3 программ дээр эх бэлтгэх чадвартай болно.	0.2	0.2	Багш бүр 3-4 программ дээр эх бэлтгэх чадвартай болно.				ХБСЗ БСУТ	
15		1.6.2 Цахим эх бэлтгэх уралдаан зохион байгуулах	2022-2024	ОНТ	1.2			0.4	Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудын дунд уралдаан зохион байгуулна.	0.4	0.4	Төрийн албан хаагчдын дунд уралдаан зохион байгуулна.		0.4		БСУТ ХБСЗ	Монгол хэл, бичгийн багш нар Төрийн байгуул лагууд
Нийт										8.6	7.5	7.9					
Зорилт 2: Бүх нийтийг монгол бичигт сургах аялыг эрчимжүүлж, албан хэргийг кирилл, монгол хос бичгээр хөтлөн явуулах бэлтгэлийг хангах зорилтын хүрээнд:																	
2.1. Төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын ажилтан, албан хаагчдын монгол бичгээр унших, бичих чадварын суурь сургалтаар анхан болон дунд, гүнзгийрүүлсэн шатны сургалтыг үе шаттай, олон арга хэлбэрээр зохион байгуулах	16	2.1.1 Байгууллага бүр монгол бичиг, кирилл бичгийн зөв бичих дүрэм, найруулан бичих чадварын суурь судалгаагаар болох	2021-2024				Төрийн байгууллага д ажилтны монгол бичгийн мэдлэг чадварын судалгаагаар болох.		Судалгааг шинэчлэх			Судалгааг шинэчлэх				ХБСЗ	Төрийн болон хувийн хэвшлийн байгуул лага
	17	2.1.2 Байгууллага бүр ажилтан, албан хаагчдын монгол бичиг, монгол хэлний мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр дотоод төлөвлөгөөт сургалтуудыг зохион байгуулдаг болох	2021-2024				Төрийн байгууллага дун 20-30 хувьд сургалт зохион байгуулна		Төрийн байгууллага дун 40-60 хувь, хувийн хэвшлийн 5-10 хувь сургалт зохион байгуулна			Төрийн байгууллага дун 80-90 хувь, хувийн хэвшлийн 15-20 хувь сургалт зохион байгуулна				ХБСЗ	Төрийн болон хувийн хэвшлийн байгуул лага
	18	2.1.3 Хэлний бодлогын салбар зөвлөлөөс албан байгууллага хувь хүмүүс рүү хандсан зорилтот сургалтуудыг зохион байгуулах	2022-2024	ОНТ	6.0	8	байгууллага	3	Сонгогдсон байгууллагуудад	2.0	2.0	Сонгогдсон байгууллагуудад		2.0		ХБСЗ	Монгол хэл, бичгийн багш нар

19	2.1.4 Төрийн албаны шалгалтад орох иргэдэд "Монгол хэл бичгийн сорилто"-ын материаллаар сургалт зохион байгуулах сургалтын хөтөлбөр төлөвлөгөөтэй болж, сургалт явуулж үр дүнг тооцдог болох	2021-2024	ОНТ	1.5	4 удаагийн сургалт	1 удаа сургалт зохион байгуулна.	-	2 удаа сургалт зохион байгуулна	0.5	2 удаа сургалт зохион байгуулна	0.5	ХБС3	ХБС3-ийг дэмжих ахмад багш нарын баг
20	2.2.2 Албан байгууллагын ажилтнуудын Монгол бичгийн мэдлэг, чадварын судалгааг жил бүр гарган шат ахиулах ажлыг жилийн ажлын төлөвлөгөөнд тусгах	2021-2024	-	-	Төрийн байгууллагын 5 хувь	Төрийн байгууллагын 40-50 хувь	-	Төрийн байгууллагын 50-70 хувь, хувийн хэвшлийн 10-20	-	Төрийн байгууллагын 70-100 хувь, хувийн хэвшлийн 20-30 хувь	-	ХБС3	Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд
21	2.3.1 Байгууллагуудын дунд монгол бичгээ сурах судлах чиглэлээр аян уралдаан тэмцээн зохион байгуулах, идэвхтэй ажиллаж байгаа байгууллагуудыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах	2021-2024	ОНТ	4.5	4 уралдаан, тэмцээн	1-2 төрлийн уралдаан зохион байгуулна	-	1-2 төрлийн уралдаан зохион байгуулна	1.5	1-2 төрлийн уралдаан зохион байгуулна	1.5	ХБС3	Төр хувийн хэвшлийн байгуул лагууд
22	2.4.1 Монгол хэл, бичгийн чиглэлээр сургалт явуулж байгаа хувь хүн, хуулийн этгээдийн судалгаа гаргах	2021-2024	-	-	1 сургалтын төв	Судалгаа гаргана	-	Судалгааг шинэчлэх, нэмэх	-	Судалгааг шинэчлэх, нэмэх	-	ХБС3	-
23	2.4.2 Монгол хэл, бичгийн чиглэлээр сургалт явуулж байгаа хамтарсан сургалт зохион байгуулах, ХБС3-өөс төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх	2022-2024	ОНТ	3.0	-	-	-	2 байгууллага 40-50 хүнд сургалт явуулсан байна.	1.0	2 байгууллага 40-50 хүнд сургалт явуулсан байна.	1.0	ХБС3	-

2.2. Аймгийн төрийн байгууллагуудын удирдах ажилтны үр дүнгийн гэрээ, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд ажилтнуудаа монгол бичиг сургах ажлыг заавал тусгаж, үр дүнг тайлагнах, байгууллага бүр Монгол хэл, бичгийн сургагч багштай болж тэдгээрээр дамжуулан монгол бичгийн сургалтыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

2.3 Монгол бичиг сурч, судалж, зааж сургаж байгаа иргэд, байгууллагуудын дунд төрөл бүрийн уралдаан тэмцээн зохион байгуулах, аян өрнүүлэх, идэвхтэй ажиллаж байгаа байгууллагуудыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах

2.4 Монгол хэл, бичгийн чиглэлээр сургалт явуулж буй хувь хүн, хуулийн этгээдийг дэмжих, хамтран ажиллах, төвүүдийн тоог нэмэгдүүлж дэмжлэг үзүүлэх

2.5 Монгол бичгийн анхан дунд, гүнзгийрүүлсэн шатны мэдлэг чадварын түвшин тогтоох	24	2021-2024	-	-	-	Анхан дунд шатны тестийн сангай болно	-	Гүнзгийрүүлсэн шатны тестийн сангай болно.	-	Иргэдээ авах шалгалтын тестийн сан бүрдсэн байна.	-	ХБСЗ	МХУЗ-ын багш нар
2.5.1 Мэргэжлийн багш нарын оролцоотойгоор монгол бичгийн анхан дунд гүнзгийрүүлсэн шатны тестийн болон даалгаврын сан бүрдүүлэх		2021-2024	-	-	-	Анхан дунд шатны тестийн сангай болно	-	Гүнзгийрүүлсэн шатны тестийн сангай болно.	-	Иргэдээ авах шалгалтын тестийн сан бүрдсэн байна.	-	ХБСЗ	МХУЗ-ын багш нар
2.5.2 Монгол бичгийн мэдлэг чадварын түвшний нотлох сертификатын загвар боловсруулах, олгодог болгох	25	2021-2024	ОНТ	3.0	-	Сертификатын загвар боловсруулсан байна	-	Сертификат олгодог болгоно.	1.0	Сертификат олгоно.	1.0	ХБСЗ	-
2.6 Төрийн бүх шатны байгууллагуудад төрийн албан хаагчийг батлагдсан стандартын дагуу хос бичгээр үндэсний хэвшихэд дэмжлэг үзүүлэх, хамтран амжилтаг	26	2022-2024	ОНТ	0.3	-	-	-	Батлагдсан стандартыг төрийн байгууллагуудад танилцуулах	-	Үндэсний бичгээр хөрвүүлэх алдаа шалгах программын сургалт зохион байгуулах	0.3	ХБСЗ	Архивын тасаг
Зорилт 3: Эх хэлний сургалтын чанарыг дээшлүүлж, багшлах боловсон хүчнийг чадваржуулах зорилтын хүрээнд:													
Нийт													
3.1 Мэргэжлийн багш нарын арга зүйг хөгжүүлэн, шинэ санаа, арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах, дэмжих	27	2022-2024	ОНТ	3.0	5 багш	-	-	Арга зүйн шинэ санаа, туршлага аас доошгүйг шалгаруулах сурталчлах	1.0	Арга зүйн шинэ санаа, туршлага аас доошгүйг шалгаруулах сурталчлах	1.0	ХБСЗ	Монгол хэл бичиг, уран зохиол, бага ангийн багш нар
3.2 Монгол хэл, бичгийн хичээлээр 6-12-р ангид анти нийтийн олимпиадыг тогтмол зохион байгуулдаг болох	28	2021-2024	ОНТ	9.0	-	Зохион байгуулалтын төлөвлөгөө гаргана	-	Монгол хэл, бичгийн хичээлээр уралдаан зохион байгуулна.	3.0	Монгол хэл бичгийн хичээлээр уралдаан зохион байгуулна	3.0	ХБСЗ БСУГ	-
3.3 Монгол хэл, бичиг, уран зохиолын хичээлийн сургалтын хэрэглэгдэхүүн, ном, сурах бичиг, гарын авлагыг хэвлүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх кабинет байгуулахад дэмжлэг үзүүлэх	29	2022-2024	ОНТ	1.5	-	-	-	Үндэсний бичгийн хичээлийн сургалтын хэрэглэгдэхүүний уралдаан зохион байгуулах / цахим, цаасан, бодит/	0.5	Уран зохиолын хичээлийн хэрэглэгдэхүүний зохион байгуулна.	0.5	БСУГ, ХБСЗ	Монгол хэл, бичиг, уран зохиолын мэргэжлийн багш нар
3.3.2 Монгол хэл, бичиг, уран зохиолын кабинетын төсөл шалгаруулах	30	2023-2024	ОНТ	16.0	-	-	-	-	-	2 кабинет байгуулна	8.0	БСУГ, ХБСЗ	Монгол хэл, бичиг, уран зохиолын

3.4 ЭЕШ, Монгол хэлний бүх нийтийн шалгалт, Монгол хэл, бичгийн үлсын олимпиад, аймаг бүсийн уралдаан тэмцээнд амжилттай оролцож, онцгой амжилт гаргасан бэлтгэгчдийг судлах, туршлага судлах, үр сургалтад хамруулах	31	3.4.1 Амжилттай ажилласан бэлтгэгчдийг дэмжиж урамшуулах, болон дотоодын аймаг улс орны туршлага судлах аялал, үйл ажиллагаанд хамруулах	2022-2024	ОНТ	3.0	-	-	-	-	-	-	-	Шалгарсан багш, ЗАН-ийг урамшуулна	1.0	Шалгарсан багш, ЗАН-ийг урамшуулна	1.0	ХБС3	ЗДТГ	
Зорилт 4. Монгол хэл, утга зохиолын нөхцөл байдалд үнэлгээ хийж, үнэлэмжийг дээшлүүлэх																			
Зорилт 4. Монгол хэл, утга зохиолын нөхцөл байдалд үнэлгээ хийж, үнэлэмжийг дээшлүүлэх																			
4.1 Эрдэнэт хотод ажиллаж амьдарч буй гадаадын иргэд болон гадаад улс оронд ажиллаж байсан монгол иргэд, гндэстний цөөнхийн хэл, сонсолын сүрхийн хэл, хүүхэд багачууд, иргэдийн судалгааг гаргаж тэдэнд зоримласан сургалтын хөтөлбөр, ном сурах бичиг, хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, сургалт зохион байгуулах	32	4.1.2 Эрдэнэт хотод ажиллаж байгаа гадаадын иргэд, гадаад улс оронд олон жил ажиллаж байсан монгол иргэд, үндэстний цөөнхийн хүүхэд багачуудад зоримласан монгол хэлний сургалтын хөтөлбөртэй болж сургалт зохион байгуулах	2022-2024	ОНТ	1.5	-	-	-	-	Хөтөлбөрийн дагуу ХБС3-өөс сургалт зохион байгуулна.	0.5	Хөтөлбөрийн дагуу ХБС3-өөс сургалт зохион байгуулна.	0.5	Хөтөлбөрийн дагуу ХБС3-өөс сургалт зохион байгуулна.	0.5	ХБС3	-		
4.2 Хэл шинжлэлийн эрдэмтэн, судлаач, багш нартай хамтран ажиллаж, судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх, СӨБ болон сургуулийн насны хүүхдийн хэл ярианы хөгжилд судалгаа хийж, дүгнэх, шинэ арга зүй боловсруулах, судалгааны ажлын үр дүнг аймаг,	33	4.2.1 МУИС-ийн болон аймгийн мэргэжлийн багш, монгол бичгийн чиглэлийн эрдэмтэн судлаачдыг Эрдэнэт хотод амьдарч байгаа угсаатнуудын хэл аялгуу судлах, өвлүүлэх чиглэлийн болон бусад судалгаа шинжилгээний ажил хийхэд дэмжлэг үзүүлэх	2022-2024	ОНТ	1.5	-	-	-	-	Судалгааны ажлууд хийж эхэлнэ.	0.5	Судалгааны бүтээлийн сангай болно.	0.5	Судалгааны бүтээлийг улсын хэмжээнд сурталчилна.	0.5	ХБС3	ЕБС, Их дээд сургууль		
4.2.2 СӨБ болон сургуулийн насны	34	4.2.2 СӨБ болон сургуулийн насны	2022-2024	ОНТ	0.6	-	-	-	-	СӨБ болон сургуулийн насны	0.2	Судалгааны ажлыг аймаг	0.2	Сурталчилж эхэлнэ.	0.2	ХБС3	СӨБ ЕБС		

улсын хэмжээнд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх	сурталчдын хэл ярианы хөгжил, үгийн сан зарэгт судалгаа хийх ажлыг дэмжих, судлаачдын ажлын үр дүнг иргэд олон нийтэд хүргэх	2021-2024	ОНТ						улсын хэмжээнд танилцуулна.				
4.3"Үндэсний бичиг үсгийн баяр"-ыг аймгийн Номын төвтэй хамтран тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулах	35	4.3.1 Жил бүр "Үндэсний бичиг үсгийн баяр"-ыг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулна.	ОНТ						Тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулна				
				3.6	78.4								
				Нийт				1.2	Тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулна				
				Нийт төсөв				20.2					
								1.2	Тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулна				
								29.6					
								1.2	Тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулна				
								28.6					
													Номын төв

-- 000 --